



TANU
SOFT

БАТЛАВ:

“Аялал Жуулчлалын Мэргэжлийн Холбоо”
НЭЭХЭ-ны Ажлын албаны дарга



/Маналжавын НАРАНГЭРЭЛ/



“ТАНУСОФТ” ХХК-ий
Гүйцэтгэх Захирал

Тану Софт ХХК

/Батмандахын НАРАНЧУЛУУН/

Байршил: “Аялал Мэргэжлийн Аялал Жуулчлалын Холбоо” байр.

Огноо: 2024.02.27. Мягмар гараг

Санамж бичиг байгуулсан тоот:

ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ САНАМЖ БИЧИГ

Энэхүү “Хамтын ажиллагааны санамж бичиг” (цаашид “Санамж бичиг” гэх)-ийг нэг талаас “Аялал Жуулчлалын Мэргэжлийн Холбоо” нийтийн эрх зүйн хуулийн этгээд (цаашид АЖМХ), нөгөө талаас РД: 6666108 дугаартай “ТАНУСОФТ” ХХК (цаашид ТАНУ), (цаашид хамтад нь “талууд” гэх) нар бид хамтын ажиллагааны хүрээнд Монгол Улсад Аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа явуулж буй компаниудын үйл ажиллагааг цахимжуулах, Бизнесийн хөгжил, Сургалт зохион байгуулах, Нийгмийн хөгжлийг дэмжих төсөл, хөтөлбөрийг хамтран зохион байгуулах зэрэг зорилгын хүрээнд “хамтын ажиллагааны санамж бичгийг” байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Талууд Монгол Улсын Иргэний хууль, Компаний тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомж, тэдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм, журмын хүрээнд хамтын ажиллагааг тус тусын нөөцөд түшиглэн хөгжүүлэхтэй холбоотой харилцааг энэхүү санамж бичгийн хүрээнд зохицуулна.
- 1.2. Санамж бичиг нь хоёр талын хамтарсан үйл ажиллагаа, судалгаа, төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дагаж мөрдвөл зохих суурь баримт бичиг болно.

ХОЁР. ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

2.1 ЦАХИМ ШИЛЖИЛГТЭЙН ЧИГЛЭЛЭЭР:

- 2.1.1 Холбогдох салбарын мэргэжилтнүүдийг цахим орчинд ажиллах чиглэлээр чадавхижуулах хамтарсан сургалт, нээлттэй хэлэлцүүлэг, семинар хамтран зохион байгуулах;
- 2.1.2 Аялал жуулчлалын салбарын ААН, Компаниудын талаарх судалгааг хийж цахим танилцуулгагүй байгууллагуудад зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх, цахим шилжилт хийх боломжийг олгох;
- 2.1.3 Уг чиглэлд хамаарах бусад хөтөлбөр, арга хэмжээг хамтран зохион байгуулах;

2.2 БИЗНЕС ХӨГЖЛИЙН ЧИГЛЭЛ:

2.2.1 Гараанаас эхлэж буй компаниудад цахим шилжилт хийхэд нь дэмжлэг үзүүлэх;

2.2.2 Хамтын ажиллагааны хүрээнд гишүүн байгууллагуудыг хөнгөлөлттэй үнийн саналаар цахим шилжилт хийхэд дэмжлэг үзүүлэх ажлыг хамтран зохион байгуулж хэрэгжүүлэх;

2.2.3 Уг чиглэлд хамаарах бусад хөтөлбөр, арга хэмжээг хамтран зохион байгуулах;

2.3 НИЙГМИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ЧИГЛЭЛ

2.3.1 Аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа явуулж буй компаниудын оролцоог хангасан нийгмийн хөгжлийг дэмжих төсөл, хөтөлбөрыг хамтран зохион байгуулах;

2.3.2 Олон нийтийн эвент, сайн дурын арга хэмжээнд салбарын ААН, Байгууллагууд, ажилтануудыг идэвхитэй хамруулахад анхаарч хамтран оролцох, үйл ажиллагааг санхүүжүүлэхтэй холбоотой тодорхой хэмжээний санхүүжилтыг босгох ажлыг хамтран хэрэгжүүлэх;

2.3.3 Уг чиглэлд хамаарах бусад хөтөлбөр, арга хэмжээг хамтран зохион байгуулах;

ГУРАВ. ХАМТЫН АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

3.1 Талууд санамж бичгээр тохиролцсон нөхцөлийн хүрээнд хамтарч ажиллах бөгөөд түүнийг харилцан тохиролцоо замаар шинэчилж, нэмэлт өөрчлөлт оруулж болно.

3.2 Санамж бичгийн хэрэгжилтийг хангах, хариуцан тайлагнах, санамж бичигт дурдсан ажлуудыг зохион байгуулаж тайлан бэлтгэх үүргийг “АЖМХ” болон “ТАНУ” хамтран хүлээнэ.

3.3 Санамж бичгийн хүрээнд хийгдэх ажлын хүрээнд хамтран болон хэсэгчилсэн төлөвлөгөө гаргаж хэрэгжилтыг талууд ханган ажиллах бөгөөд талууд өөр хоорондын уялдаа холбоотой, дэмжлэгтэй ажиллах.

3.4 Талууд энэхүү санамж бичгээр харилцан тохиролцоогүй үйл ажиллагааг хамтран хэрэгжүүлэхдээ тусгайлан гэрээ байгуулж, ажлын төлөвлөгөө гаргаж, дүгнэлт өгч ажиллах замаар хэрэгжүүлнэ.

3.5 Талууд хамтын ажиллагааны хүрээнд зохион байгуулсан, хэрэгжүүлсэн ажлын талаарх мэдээллийг тус тусын мэдээллийн сувгаар олон нийтэд түгээх;

3.6 Санамж бичгийн хэрэгжилтыг нэг жилээр дүгнэж гэрэл зургаар баталгаажуулсан тайлан бэлтгэж архивлана.

ДӨРӨВ. САНАМЖ БИЧГИЙН ХҮЧИН ТӨГӨЛДӨР БАЙДАЛ, ХАРИУЦЛАГА

4.1 Энэхүү санамж бичиг нь талууд гарын үсэг зурж, баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болох бөгөөд нэг жилийн хугацаанд хүчинтэй байх ба хоёр хувь үйлдэж, бичвэрүүд нэгэн адил хүчинтэй байна.

4.2 Энэхүү санамж бичгийн биелэлтийг жил бүр дүгнэж, санамж бичгийн хүрээнд байгуулагдсан гэрээнүүдийг (сургалтын, арга хэмжээ, төсөл, судалгаа, дадлагын, зөвлөх үйлчилгээний г.м.) дүгнэнэ.

4.3 Санамж бичгийн хугацаа дуусахаас 30 хоногийн өмнө аль нэг тал цуцлах хүсэлтээ бичгээр гараагүй бол санамж бичиг нэг жилээр сунгагдсанд тооцно.

4.4 Талуудын аль нэг тал санамж бичгийн хугацаа дуусах өдрөөс 30 хоногийн өмнө санамж бичгийг цуцлах хүсэлтээ бичгээр, цуцлах шаардлага бүхий үндэслэлтэй мэдэгдсэн тохиолдолд /Үндэслэл гэдэг нь хууль зөрчсөн үйлдлийг хэлэх ба бусад тохиолдол нь гэрээ цуцлах үндэслэл болохгүй./ уг санамж бичгийг цуцлах бөгөөд бусад тохиолдолд аль нэг талын санаачлагаар цуцлахгүй.


4.5 Санамж бичгийн хүрээнд талууд бие биенээ харилцан дэмжиж үр дүн гарган хамран ажиллана.

4.6 Талууд санамж бичгийн хүрээнд хамтран ажиллах, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, зөвлөх үйлчилгээ үзүүлэхдээ хариуцлагатай хандаж хоёр талын нэр хүнд, цар хүрээг тэлэх чиглэлээр үргэлж идэвхи санаачлагатай байж гэрээний хэрэгжилтийг идэвхитэй, хариуцлагатай ханган ажиллана.

4.7 Хамтын ажиллагааны санамж бичгийг хэрэгжүүлэх явцад үүссэн маргааныг талууд харилцан зөвшилцлийн үндсэн дээр шийдвэрлэнэ.

САНАМЖ БИЧИГ БАЙГУУЛСАН:


Аялал Жуулчлалын Мэргэжлийн Холбооны
дотоод үйл ажиллагаа хариуцсан менежер:



М.ДАРХИЖАВ/

Утас: 77128822, 98888803, 99030928
Имэйл: tourism.mongol@gmail.com
Веб:

“ТАНУСОФТ” ХХК-ий
Вэб хөгжүүлэгч:



/М.ДӨЛГӨӨН/

Утас: 77001005, 88661005, 88200314
Имэйл: info.tanusoft@gmail.com
Веб: www.tanusoft.mn

ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ САНАМЖ БИЧИГ

2024 оны 03 сарын 22-ны өдөр

Улаанбаатар хот

Монгол Улсын Аялал жуулчлал, Гэрэл зургийн салбар хоорондын хамтын ажиллагааг хангах, Монгол орон, аялал жуулчлалын салбарыг дэлхийд сурталчлах, гэрэл зургийн үнэ цэнийг нэмэгдүүлэх, оюуны өмч, зохиогчийн эрхийг хамгаалах, Монголын гэрэл зурагчдын бүтээлийг олон улсад таниулах, Гэрэл зургаар дамжуулан аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг сурталчлах зорилгоор “Монголын Гэрэл Зурагчдын Нэгдсэн Холбоо” ГҮТББ болон “Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо” НЭЗХЭ нар харилцан тохиролцож, харилцан эрх ашгийг хүндэтгэн, үйл ажиллагаанд нь харилцан дэмжлэг үзүүлэх зарчимд тулгуурлан дараах чиглэлүүдээр хамтран ажиллах тухай энэхүү САНАМЖ БИЧГИЙГ байгуулж байна.

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Талууд харилцан тохиролцсоны үдсэн дээр сайн дураар, хууль журмыг хүндэтгэн, харилцан эрх ашгийг хамгаалан, хамтын ажиллагааны зарчимд тулгуурлан харилцан ойлголцож, энэхүү санамж бичигт гарын үсэг байгуулсан болно.

1.2. Талууд хамтын ажиллагаандаа хууль дээдлэх, байгууллага хоорондын харилцааны зохистой хэм хэмжээг баримтлан, харилцан санал солилцох, зөвшилцөх, эрх тэгш байдлыг эрхэмлэх, талууд нээлттэй, ил тод байх, үр бүтээлтэй хамтран ажиллах зарчмуудыг баримтална.

1.4. Талууд цаашдын албан ёсны хуулийн харилцаанд орж хамтран ажиллахдаа холбогдох гэрээ хэлцлийг байгуулан ажиллана.

Хоёр. Хамтын ажиллагааны зорилго

2.1. Энэхүү санамж бичгийн хүрээнд хэрэгжүүлэх хамтын ажиллагааны зорилго нь Монгол Улсын Аялал жуулчлал, Гэрэл зургийн салбар хоорондын хамтын ажиллагааг хангах, Монгол орон, аялал жуулчлалын салбарыг дэлхийд сурталчлах, гэрэл зургийн үнэ цэнийг нэмэгдүүлэх, оюуны өмч, зохиогчийн эрхийг хамгаалах, Монголын гэрэл зурагчдын бүтээлийг олон улсад таниулах, Гэрэл зургаар дамжуулан аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг сурталчлахад оршино.

Гурав: Хэрэгжүүлэх арга хэмжээ

3.1. Гэрэл зурагчид, аялал жуулчлалын компаниуд нээлттэй, харилцан ашигтай хамтран ажиллах дэмжлэг үзүүлэх, холбогдох аргачлал платформыг хөгжүүлэх;

3.2. Монгол орныг олон улсад сурталчлахад гэрэл зургийг ашиглах;

3.3. Гэрэл зурагчдын бүтээлийн зургийн үнэ цэнийг нэмэгдүүлэх;

3.4. Гэрэл зурагчдын оюуны өмч, зохиогчийн эрхийг хамгаалах;

3.5. Дотоодын болон олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн, эвент, үйл ажиллагаа, хэвлэмэл болон цахим орчинд гэрэл зурагчдын бүтээлийг холбогдох гэрээ, хэлцлийн дагуу ашиглах;

3.6. Монгол орон, үндэсний брэндийг сурталчлахад хамтран ажиллах;

3.7. Гэрэл зурагчид өөрсдийн бүтээлээр дамжуулан аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг сурталчлах, хамтарсан аялал зохион байгуулах;

3.8. Аялал жуулчлалын эвент дээр гэрэл зургийн үзэсгэлэн гаргах;

3.9. Гэрэл зурагчдын бүтээл болон фото, видео дүрсийг нэгдсэн байдлаар эзэмших эрхийг худалдах, худалдан авах, тодорхой хугацаанд ашиглах боломжтой байдлаар гэрээ, хэлцэл байгуулах, харилцан ашигтай хамтран ажиллах;

3.10. Аялал жуулчлалын үйл ажиллагаа, эвентийн үеэр зураг авах, видео бичлэг хийхэд хамтран ажиллах;

3.11. Гэрэл зурагчдын бүтээлийн үнэ цэнийг нэмэгдүүлэх, оюуны өмчийг хамгаалах чиглэлд аялал жуулчлалын байгууллагуудад мэдлэг, мэдээлэл олгоход дэмжлэг үзүүлэх;

3.12. Аялал жуулчлалын компаниудыг дэмжих, хамтран ажиллах мэдлэг, мэдээллийг Гэрэл зурагчдад олгоход дэмжлэг үзүүлэх;

3.13. Салбарын хамтын ажиллагаа, дэлхийн чиг хандлагын талаарх мэдээллийг солилцох;

3.14. Аялал жуулчлалын эвент, үйл ажиллагаанд Гэрэл зурагчдын төлөөллийг урин оролцуулах;

Дөрөв. Баталгаа

- 4.1 Энэхүү санамж бичиг нь гэрээ биш бөгөөд гэрээ, эрх зүйгээр зохицуулагддаг аливаа эрх, үүрэг үүсэхгүй.
- 4.2 Энэхүү санамж бичгийн дагуу хоёр жилийн хугацаанд хамтран ажиллахаар харилцан тохиролцов.
- 4.3 Санамж бичгийг мөрдөгдөх хугацаанд хийгдсэн үйл ажиллагааны үр дүнг дүгнэн, цаашдын хамтын ажиллагааг тодорхойлно.
- 4.4 Энэхүү санамж бичгийг Улаанбаатар хотноо 2024 оны 03 сарын 22 өдөр хоёр эх хувь үйлдэв.

САНАМЖ БИЧИГ БАЙГУУЛСАН:

“АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
МЭРГЭЖЛИЙН ХОЛБОО” НЭЗХЭ:

АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА



М.НАРАН ЭРЭЛ

Хаяг: СБД, 1 хороо, Очир центр, 5
давхар 503 тоот, Улаанбаатар хот,
Монгол Улс

“МОНГОЛЫН ГЭРЭЛ ЗУРАГЧДЫН
НЭГДСЭН ХОЛБОО” ГҮТББ:

ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА



Ц.БАТБААТАР

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар
дүүрэг, Амарын гудамж-15
Туушин оффис 501 тоот

“МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ХУДАЛДАА АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМ” ТӨРИЙН БУС
БАЙГУУЛЛАГА

“АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН МЭРГЭЖЛИЙН ХОЛБОО” НИЙТИЙН ЭРХ ЗҮЙН ХУУЛИЙН ЭТГЭЭД

ХАМТРАН АЖИЛЛАХ САНАМЖ БИЧИГ

2024 оны 04 сарын 15-ны өдөр

Улаанбаатар хот

Монгол Улсад бизнесийн таатай орчныг бүрдүүлэх, Аялал жуулчлалын болон бизнесийн салбар хооронд хамтран ажиллах, экспортыг нэмэгдүүлэх, олон улсын олон дотоодын байгууллагууд, гишүүд хоорондын хамтын ажиллагааг дэмжих зорилгоор “Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим” ТББ (Цаашид “МҮХАҮТ” гэх) болон “Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо” НЭЗХЭ (Цаашид “АЖМХ” гэх) нар харилцан тохиролцож, харилцан эрх ашгийг хүндэтгэн, үйл ажиллагаанд нь харилцан дэмжлэг үзүүлэх зарчимд тулгуурлан дараах чиглэлүүдээр хамтран ажиллах тухай энэхүү САНАМЖ БИЧГИЙГ байгуулж байна.

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Талууд харилцан тохиролцсоны үдсэн дээр сайн дураар, хууль журмыг хүндэтгэн, харилцан эрх ашгийг хамгаалан, хамтын ажиллагааны зарчимд тулгуурлан харилцан ойлголцож, энэхүү санамж бичигт гарын үсэг байгуулсан болно.
- 1.2. Талууд хамтын ажиллагаандаа хууль дээдлэх, байгууллага хоорондын харилцааны зохистой хэм хэмжээг баримтлан, харилцан санал солилцох, зөвшилцөх, эрх тэгш байдлыг эрхэмлэх, талууд нээлттэй, ил тод байх, үр бүтээлтэй хамтран ажиллах зарчмуудыг баримтална.
- 1.3. Талууд цаашдын албан ёсны хуулийн харилцаанд орж хамтран ажиллахдаа холбогдох гэрээ хэлцлийг байгуулан ажиллана.

Хоёр. Хамтын ажиллагааны зорилго

- 2.1. Энэхүү санамж бичгийн хүрээнд хэрэгжүүлэх хамтын ажиллагааны зорилго нь Монгол Улсад бизнесийн таатай орчныг бүрдүүлэх, Аялал жуулчлалын болон бизнесийн салбар хооронд хамтран ажиллах, экспортыг нэмэгдүүлэх, олон улсын олон дотоодын байгууллагууд, гишүүд хоорондын хамтын ажиллагааг дэмжихэд оршино.

Гурав: Хэрэгжүүлэх арга хэмжээ

- 3.1. Монгол Улсад бизнесийн бүхий л салбарууд болон Аялал жуулчлалын салбарт бизнес эрхлэх таатай орчин бүрдүүлэх;

- 3.2. Бизнесийн салбар хоорондын харилцан ашигтай хамтын ажиллагааг дэмжих;
- 3.3. МҮХАҮТ, АЖМХ гишүүдийн бизнесийн харилцаа, холбоог дэмжих;
- 3.4. ОУ-ын хурал, уулзалтанд хамтран оролцох, аялал жуулчлалын чиглэлд хамтран зохион байгуулах;
- 3.5. Аялал жуулчлал, экспортын стратегийг боловсруулах, хөгжүүлэхэд хамтран ажиллах;
- 3.6. МҮХАҮТ -ийн үйл ажиллагаа, хурал уулзалтын талаарх мэдээллийг АЖМХ гишүүддээ хүргэх;
- 3.7. Аялал жуулчлалын салбар бизнес эрхлэгчдэд зориулсан сургалт зохион байгуулах;
- 3.8. МҮХАҮТ-ыг аялал жуулчлалын салбарын мэдээлэл, тоо статистикаар хангах;
- 3.9. Хамтын ажиллагааны зорилтуудын хүрээнд өөрсдийн гишүүдэд мэдээлэл хүргэх, сурталчилах;
- 3.10. МҮХАҮТ-с зохион байгуулагдаж буй сургалтуудад АМЖХ гишүүд хөнгөлөлттэй үнээр суралцах боломжийг олгох;
- 3.11. Бизнесийн салбарт технологийн шинэчлэлийг нэвтрүүлэх, инновацийн төслүүдэд хамтран ажиллах;
- 3.12. Аялал жуулчлалын салбар, аялал жуулчлалын салбараар дамжуулан Монгол Улсад гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татах;
- 3.13. Стартап, шинэ бизнесийн санаачлагуудад дэмжлэг үзүүлэх;
- 3.14. МУ-ын Засгийн газар, төрийн байгууллагад хамтын санал, дуу хоолойг хүргэх;
- 3.15. Зорилгын хүрээнд хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, нийгмийн хариуцлагын төслүүдэд оролцох;
- 3.16. МҮХАҮТ-ын танхим, үйлчилгээг хөнгөлөлттэй үнээр ашиглах, түрээслэх;
- 3.17. Аялал жуулчлалын салбарын байгууллага хоорондын маргааныг Арбитрийн шүүхээр шийдвэрлүүлэхэд хамтран ажиллах;
- 3.18. Хууль тогтоомжийн өөрчлөлт, шинэчлэлтэй холбоотой мэдээллийг солилцох.

Дөрөв. Баталгаа

- 4.1 Энэхүү санамж бичиг нь гэрээ биш бөгөөд гэрээ, эрх зүйгээр зохицуулагддаг аливаа эрх, үүрэг үүсэхгүй.
- 4.2 Энэхүү санамж бичгийн дагуу хоёр жилийн хугацаанд хамтран ажиллахаар харилцан тохиролцов.
- 4.3 Санамж бичгийг мөрдөгдөх хугацаанд хийгдсэн үйл ажиллагааны үр дүнг дүгнэн, цаашдын хамтын ажиллагааг тодорхойлно.
- 4.4 Энэхүү санамж бичгийг Улаанбаатар хотноо 2024 оны 04 сарын 15 өдөр хоёр эх хувь үйлдэв.

САНАМЖ БИЧИГ БАЙГУУЛСАН:

“МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ХУДАЛДАА
АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМ” -ЫН
ДЭРГЭДЭХ
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЗӨВЛӨЛИЙН
ДАРГА

.....
Б.БАРСБОЛД

Хаяг: ХУД, 15-р хороо, Махатма
Гандигийн гудамж, МҮХАҮТанхимын
байр, Улаанбаатар хот, Монгол Улс

“АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
МЭРГЭЖЛИЙН ХОЛБОО” НЭЗХЭ:

ЕРӨНХИЙЛӨГЧ

.....
Ц.БААТАРСАЙХАН

Хаяг: СБД, 1 хороо, Очир центр, 5
давхар 503 тоот, Улаанбаатар хот,
Монгол Улс



MONGOLIA
TOURISM ORGANIZATION
LEGAL ENTITY OF PUBLIC LAW



“АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН МЭРГЭЖЛИЙН ХОЛБОО” НИЙТИЙН ЭРХ ЗҮЙН ХУУЛИЙН ЭТГЭЭД

БНХАУ-ЫН 10000 МАЙЛС КЛУБ

МОНГОЛЫН ЧОППЕРЧИН АХАН ДҮҮС НҮТББ

ХАМТРАН АЖИЛЛАХ САНАМЖ БИЧИГ

2024 оны 04 сарын 18-ны өдөр

Улаанбаатар хот

Монгол Улсад бизнесийн таатай орчныг бүрдүүлэх, Аялал жуулчлалын болон бизнесийн салбар хооронд хамтран ажиллах, олон улсын байгууллагууд, гишүүд хоорондын хамтын ажиллагааг дэмжих зорилгоор “Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо” НЭЗХЭ (Цаашид “АЖМХ” гэх) нар харилцан тохиролцож, харилцан эрх ашгийг хүндэтгэн, үйл ажиллагаанд нь харилцан дэмжлэг үзүүлэх зарчимд тулгуурлан дараах чиглэлүүдээр хамтран ажиллах тухай энэхүү САНАМЖ БИЧГИЙГ байгуулж байна.

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Талууд харилцан тохиролцсоны үдсэн дээр сайн дураар, хууль журмыг хүндэтгэн, харилцан эрх ашгийг хамгаалан, хамтын ажиллагааны зарчимд тулгуурлан харилцан ойлголцож, энэхүү санамж бичигт гарын үсэг байгуулсан болно.
- 1.2. Талууд хамтын ажиллагаандаа хууль дээдлэх, байгууллага хоорондын харилцааны зохистой хэм хэмжээг баримтлан, харилцан санал солилцох, зөвшилцөх, эрх тэгш байдлыг эрхэмлэх, талууд нээлттэй, ил тод байх, үр бүтээлтэй хамтран ажиллах зарчмуудыг баримтална.
- 1.3. Талууд цаашдын албан ёсны хуулийн харилцаанд орж хамтран ажиллахдаа холбогдох гэрээ хэлцлийг байгуулан ажиллана.

Хоёр. Хамтын ажиллагааны зорилго

- 2.1. Энэхүү санамж бичгийн хүрээнд хэрэгжүүлэх хамтын ажиллагааны зорилго нь Монгол Улсад бизнесийн таатай орчныг бүрдүүлэх, Аялал жуулчлалын болон бизнесийн салбар хооронд хамтран ажиллах, олон улсын байгууллагууд, гишүүд хоорондын хамтын ажиллагааг дэмжихэд оршино.

Гурав: Хэрэгжүүлэх арга хэмжээ

- 3.1. Монгол Улсын Аялал жуулчлалын салбарт бизнес эрхлэх таатай орчин бүрдүүлэх;
- 3.2. Талуудын аялал жуулчлалын салбар хоорондын харилцан ашигтай хамтын ажиллагааг дэмжих;
- 3.3. ОУ-ын аялал жуулчлалын хурал, уулзалтанд хамтран оролцох, аялал жуулчлалын чиглэлд хамтран зохион байгуулах;
- 3.4. Аялал жуулчлал стратегийн төлөвлөгөө хамтран боловсруулах;
- 3.5. Аялал жуулчлалын салбар бизнес эрхлэгчдэд зориулсан сургалт зохион байгуулах;

- 3.6. Аялал жуулчлалын салбарт технологийн шинэчлэлийг нэвтрүүлэх, инновацийн төслүүдэд хамтран ажиллах;
- 3.7. Аялал жуулчлалын салбараар дамжуулан Монгол Улсад Хятадын аялал жуулчлалын хөрөнгө оруулалтыг татах;
- 3.8. Зорилгын хүрээнд хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх;
- 3.9. Талуудын Хил орчмын болон Хил дамнасан аялал жуулчлалыг хөгжүүлэх.

Дөрөв. Баталгаа

- 4.1 Энэхүү санамж бичиг нь гэрээ биш бөгөөд гэрээ, эрх зүйгээр зохицуулагддаг аливаа эрх, үүрэг үүсэхгүй.
- 4.2 Энэхүү санамж бичгийн дагуу хоёр жилийн хугацаанд хамтран ажиллахаар харилцан тохиролцов.
- 4.3 Санамж бичгийг мөрдөгдөх хугацаанд хийгдсэн үйл ажиллагааны үр дүнг дүгнэн, цаашдын хамтын ажиллагааг тодорхойлно.
- 4.4 Энэхүү санамж бичгийг Улаанбаатар хотноо 2024 оны 04 сарын 18 өдөр хоёр эх хувь үйлдэв.

САНАМЖ БИЧИГ БАЙГУУЛСАН:



“АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
МЭРГЭЖЛИЙН ХОЛБОО”
НЭЗХЭ:

АЖМЖ-ны Хятад зах зээлийн
холбооны тэргүүн
Г.Отгонбаатар



БНХАУ-ЫН 10000 МАЙЛС КЛУБ
КЛУБЫН ТЭРГҮҮН

Юү Зишү
МОНГОЛЫН ЧОЛПЕРЧИН
АХАН ДҮҮС НҮТББ
Ш.Сүхбаяр





蒙古国旅游协会
中国万里骑士俱乐部
蒙古国美式摩托车俱乐部

跨境旅游合作备忘录

2024年4月18日

乌兰巴托市

为了在蒙古国创造良好的旅游环境，促进蒙古国旅游业和国际旅游组织和企业之间的合作，并支持众多国内外旅游组织和会员之间的合作，蒙古国旅游协会、中国万里骑士俱乐部与蒙古国美式摩托车俱乐部三方签订跨境旅游合作备忘录。根据双方同意、尊重共同利益和共同利益的原则签署本备忘录，在以下领域开展合作。

一、 宗旨

- 1.1. 按照双方达成的共识，双方自愿，本着尊重法律，维护共同利益的合作原则，签署本合作备忘录。
- 1.2. 合作各方应遵循法律原则、规范合作、相互间交换意见，并协商一致、在平等、公开透明、务实的合作。
- 1.3. 双方以后正式建立合作关系、签订相关协议进行合作。

二、 合作目的

- 2.1. 本合作备忘录框架合作的目的是在蒙古国创造良好的旅游环境，促进蒙古国旅游业和国际旅游组织和企业之间的合作，并支持众多国内外旅游组织和会员之间的合作。

三、 未来共同实施的措施

- 3.1. 在蒙古国旅游业领域创造良好的商业环境；
- 3.2. 促进双方旅游行业间的互利合作；

- 3.4. 共同制定旅游业战略规划;
- 3.5. 共同举办旅游培训;
- 3.6. 引进旅游领域新技术, 开展创新项目合作;
- 3.7. 在蒙古国旅游业领域引进中国旅游投资;
- 3.8. 共同开展联合项目;
- 3.9. 共同发展边境地区和跨境旅游。

四、保证

- 4.1. 本合作备忘录不是合同, 不产生任何受法律管辖的权利或义务。
- 4.2. 按照本合作备忘录, 双方同意为期两年开展合作。
- 4.3. 将总结备忘录执行期间开展的活动成果并确定未来的合作。
- 4.4. 于 2024 年 4 月 18 日在乌兰巴托签署一式两份合作备忘录。


建立合作备忘录:

蒙古国旅游协会
中国市场分会会长




格·奥特根巴特尔

中国万里骑士乐部会长


于子竖

蒙古国美式摩托车俱乐部会长



希·苏赫巴亚尔



Mongolia Tourism Organization
Legal Entity of Public Law

**MEMORANDUM OF UNDERSTANDING
BETWEEN THE MONGOLIA TOURISM
ORGANIZATION AND MONGOLIA
CENTER NON-GOVERNMENTAL
ORGANIZATION**

Dare: 18th April 2024

Ulaanbaatar,

Mongolia

The Memorandum of Understanding (MOU) signed by the Mongolia Tourism Organization and Mongolia center non-governmental organization.

RECOGNISING that the Parties are desirous to enhance the bilateral cooperation and strengthen the ties of the existing friendship between the two countries and realizing the importance of the tourism sector in the economic development and mutual interest on equal grounds.

EMPHASIZING the need to strengthen, deepen and enhance the bilateral cooperation in tourism.

RECOGNIZING further the importance of tourism in enhancing knowledge and understanding amongst their people.

TAKING INOT ACCOUNT THE IMPORTANCE OF THE Parties as partners and the main sources of markets for tourism between the two countries.

HAVE REACHED the following understanding:

ARTICLE – I

The Parties will establish of the branch of Mongolia Tourism Organization in Federal Republic of Germany, in accordance with the national laws of each of the countries.

ARTICLE – II

The branch shall implement promotion of Mongolia in tourism.

ARICLE – III

The branch shall organize tourism exhibition of Mongolia.

ARTICLE- IV

The branch shall perform activity of selling products and services of Mongolian tourism.

ARTICLE-V

The Parties will encourage the exchange of information and data related to tourism as well as the exchange of experiences in the areas of promotion, marketing, destinations development and management, amongst others of interest to the Parties.

ARTICLE- VI

The Parties shall promote their participation in the international exhibition which are organized by each of the Parties in their countries and provide necessary facilities to the other Party's delegates to participate in the international tourist seminars and conferences, as well as workshops conducted in their respective countries.

ARTICLE- VII

The Parties may constitute a Joint Working Group which shall include an equal number of representatives from both the sides of the implementation of this Memorandum. The Joint Working Group may meet alternatively in each country at a convenient date and place mutually agreed upon.

ARTICLE – VIII

The Parties shall make agreement which incorporates finance, commission, structure, and other issues of the branch.

ARTICLE- IX

Every activity undertaken under this Memorandum of Understanding shall be subject to the respective internal legal framework of each of the Parties.

ARTICLE-X

This Memorandum of Understanding is not legally binding and does not generate any obligations in the scope of the Public International Law.

ARTICLE – XI

Any differences or dispute arising out of the interpretation and implementation or application of any of the provisions of this Memorandum of Understanding (MoU) shall be settled amicably through mutual consultations or negotiations between the parties.

ARTICLE- XII

Either Party may request at any time in writing an amendment or all or any part of this Memorandum of Understanding.

This Memorandum of Understanding shall come into effect on the date of its signature and shall remain in effect of period of five (5) years. Thereafter, it shall be automatically renewed for similar successive periods at a time, unless either Party may terminate the present Memorandum by giving a writing notice of its intention to terminate to the other Party at least six (6) months in advance.

Termination of the present Memorandum shall not affect the implementation of the projects which are already in progress under the present Memorandum and will be continued in accordance with the terms and conditions of the present Memorandum.

IN WITNESS WHEREOF, Parties have signed this Memorandum of Understanding in two originals copies each in English all texts being equally authentic. In case of any divergence in interpretation, the English text shall prevail.

For the Mongolia Tourism Organization

For the Mongolia Center NGO

NAME: President Baatarsaikhan.Ts

NAME:

“АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
МЭРГЭЖЛИЙН ХОЛБОО” НЭЗХЭ

“МИАТ” ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААГ
КОМПАНИ

ЕРӨНХИЙЛӨГЧ

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ц.БААТАРСАЙХАН

Б.МӨНХТАМИР

ХАМТРАН АЖИЛЛАХ САНАМЖ БИЧИГ

2024 оны 04 сарын 25-ны өдөр

Улаанбаатар хот

Монгол Улсын Засгийн Газраас 2023-2025 оныг “Монголд зочлох жил” болгон зарласантай холбогдуулах Монгол Улсын аялал жуулчлалын салбар болон Үндэсний агаарын тээвэрлэгч компани хоорондын харилцан ашигтай, урт хугацааны хамтын ажиллагааг бий болгох зорилгоор “МИАТ” Төрийн өмчит хувьцаат компани (Цаашид “МИАТ” гэх) болон “Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо” Нийтийн эрх зүйн хуулийн этгээд (Цаашид “АЖМХ” гэх) нар нь хамтран ажиллахаар энэхүү САНАМЖ БИЧГИЙГ байгуулав.

Нэг. ХАМТРАН АЖИЛЛАХ ЗОРИЛГО

1.1. Төрөөс аялал жуулчлал, иргэний нисэхийн салбарт баримтлах бодлого, чиглэлд хамтран санал өгөх, иргэний нисэхийн салбарын үйл ажиллагаанд оролцогчдын уялдаа холбоог сайжруулж, хөгжлийн стратегийг боловсруулахад хамтран санал өгөх;

1.2. Олон улсад Монгол улсыг сурталчлан таниулах тал дээр хамтран ажиллах;

Дээрх зорилгын хүрээнд хамтран ажиллах чиглэлийг энэхүү санамж бичгийн Хавсралт №1-д нарийвчлан тодорхойлов.

Хоёр. ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

2.1. Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр сайн дураар, хууль журмыг хүндэтгэн, харилцан эрх ашгийг хамгаалан, хамтын ажиллагааны зарчимд тулгуурлан харилцан ойлголцож, энэхүү санамж бичигт гарын үсэг байгуулсан болно.

“МИАТ” ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ, “АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН МЭРГЭЖЛИЙН ХОЛБОО” НИЙТИЙН ЭРХ ЗҮЙН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ХАМТРАН АЖИЛЛАХ САНАМЖ
БИЧГИЙН ХАВСРАЛТ №1

ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

1. Монгол Улсын аялал жуулчлал, агаарын тээврийн салбарыг хөгжүүлэх, хамтын ажиллагааг дэмжих;
2. МИАТ компани болон аялал жуулчлалын компаниудын хоорондын харилцан ашигтай хамтын ажиллагааг дэмжих;
3. МИАТ компани шинэ чиглэл гаргах, нислэгийн тоог нэмэгдүүлэхэд суурь судалгаа, жуулчдын эрэлтийн талаарх мэдээллийг АЖМХ-с хангах, гадаадын аялал жуулчлалын холбоод, тур оператор компаниудад нислэгийн талаарх мэдээллийг хүргэх замаар борлуулалтыг дэмжих;
4. Олон улсад Монгол улсыг сурталчлах тал дээр хамтран ажиллах, Гадаадын тур оператор компаниуд, аялал жуулчлалын холбоодод МИАТ компанийг сурталчлах, нислэгийн хуваарь, шинэ маршрут, хямдрал, урамшууллын мэдээллийг хүргэх;
5. АЖМХ дотоодын болон олон улсын агаарын тээврийн нислэгийн эрэлтийн мэдээллээр МИАТ компанийг хангах;
6. Гадаадын аялал жуулчлалын үзэсгэлэнд АЖМХ, тус холбооны гишүүд оролцоход МИАТ компанийн зүгээс дэмжин хамтран ажиллах;
7. Гадаадын аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцоход МИАТ компанийг сурталчилгаа хийх боломжоор хангах, холбогдох танилцуулга, мэдээллийг байрлуулах;
8. ОУ-ын хурал, уулзалт, үзэсгэлэнд хамтран оролцох, аялал жуулчлалын чиглэлд хамтран зохион байгуулах;
9. МИАТ компанийн үйл ажиллагаа, үнийн тариф, хямдрал урамшуулал, шинэ маршрутын талаарх мэдээллийг АЖМХ-ны гишүүдэд хүргэх;
10. Агаарын тээврийн нислэгийн мэдээлэл болон бусад олон нийтэд нээлттэй статистик мэдээллээр хангах ;
11. МИАТ компанийг АЖМХ-с аялал жуулчлалын салбарын статистик мэдээлэл, судалгаа, гадаад болон дотоод жуулчдын зорчих хандлага, шинээр гарч буй аяллын бүтээгдэхүүний чиг хандлага талаарх мэдээллээр хангах;
12. МИАТ компанийн нислэгийн дүүргэлт, улирлын онцлогоос хамаарч аялал жуулчлалын компаниудаар дамжуулан групп зочдын хямдрал, урамшуулал тусгайлан зарлах;
13. АЖМХ-с зохион байгуулж буй аялал жуулчлалын талаарх хэлэлцүүлэг, сургалт, уулзалтад МИАТ компанийг урин оролцуулах, иргэний агаарын тээврийн талаар санал солилцох;
14. МУ-ын Засгийн газар, харьяалагдах яамд, төрийн байгууллагад хамтын санал, дуу хоолойг хүргэх;
15. Зорилгын хүрээнд хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, нийгмийн хариуцлагын төслүүдэд оролцох;

- 2.2. Энэхүү санамж бичиг нь гэрээ биш бөгөөд гэрээ, эрх зүйгээр зохицуулагддаг аливаа эрх, үүрэг үүсэхгүй. Талууд цаашдын албан ёсны хуулийн харилцаанд орж хамтран ажиллахдаа холбогдох гэрээ хэлцлийг байгуулан ажиллана.
- 2.3. Талууд хоёр жилийн хугацаатай хамтран ажиллахаар харилцан тохиролцов.
- 2.4. Санамж бичгийг мөрдөгдөх хугацаанд хийгдсэн үйл ажиллагааны үр дүнг дүгнэн, цаашдын хамтын ажиллагааг тодорхойлно.

САНАМЖ БИЧИГ БАЙГУУЛСАН:


“АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
МЭРГЭЖЛИЙН ХОЛБОО” НЭЗХЭ

“МИАТ” ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААГ
КОМПАНИ

Хаяг: СБД, 1 хороо, Очир центр, 5
давхар 503 тоот, Улаанбаатар хот,
Монгол Улс

Хаяг: Буянт-Ухаа 45, Хан-Уул дүүрэг,
Улаанбаатар хот-17120, Монгол Улс

ХАРИЛЦАН ОЙЛГОЛЦЛЫН САНАМЖ БИЧИГ



“АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН МЭРГЭЖЛИЙН ХОЛБОО” НЭЗХЭ

Хаяг: Улаанбаатар, Сүхбаатар, 8-р хороо, Централ тауэр, 912 тоот

И-мэйл: info@mto.mn

Х



“ЮБИКАБ” ХХК

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
1-р хороо, Нарны зам гудамж, Юбикаб ХХК-н төв оффис

И-мэйл: info@ubcab.mn

Утас: 7780-7780

Х



“ТОМЁ ЭДТЕК” ХХК

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
8-р хороо, Чингисийн талбай-5, Сити Тауэр, 1001 тоот

И-мэйл: hello@tomyo.mn

Утас: 77003336

2024 оны 05-р сарын 15-ны өдөр
Монгол улс, Улаанбаатар хот

ХАРИЛЦАН ОЙЛГОЛЦЛЫН САНАМЖ БИЧИГ

2024 оны 05 дугаар сарын 15-ны өдөр
хот

№

Улаанбаатар

Энэхүү харилцан ойлголцлын санамж бичиг (цаашид "Санамж бичиг" гэх)-ийг нэг талаас "Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо" Нийтийн эрх зүйн хуулийн этгээд (цаашид "холбоо" гэх) түүнийг төлөөлж Дэд ерөнхийлөгч О.Мөнхнасан,

Нөгөө талаас "Юбикаб" ХХК (цаашид "Юбикаб" гэх), түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал О.Золбаяр,

Нөгөө талаас "Томё Эдтек" ХХК (цаашид "Томё" гэх, хамтад нь "Талууд" гэх), түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал Б.Батзул нар нь дор дурдсан нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав.

Нэг. Хамтран ажиллах чиглэл

- 1.1. Энэхүү Санамж бичгийг талуудын хамтын ажиллагааг хөгжүүлэх, Монгол улсад айлчлан ирсэн жуулчдын гэврийн харилцааг зохицуулах зорилго бүхий "Жуулчдад ээлтэй жолооч" төслийг хамтран хэрэгжүүлэх зорилгоор байгуулав.
- 1.2. Энэхүү санамж бичгийн хүрээнд талууд дараах асуудлаар хамтран ажиллах боломжтойгоо харилцан илэрхийлж байна. Үүнд:

Холбооны хэрэгжүүлэх арга хэмжээ:

- 1.2.1. Төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой дэмжлэг, туслалцаа үзүүлэх,
- 1.2.2. Төслийн мэдээллийг жуулчдад хүргэх, сурталчлах, жуулчдад хүртээмжтэйгээр хэрэгжүүлэх,
- 1.2.3. Бодлого, арга зүйн зөвлөгөө өгөх,
- 1.2.4. Төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой бусад,

Юбикабын хэрэгжүүлэх арга хэмжээ:

- 1.2.5. Өөрийн Ubcab аппликейшнд бүртгэлтэй жолооч нараар дамжуулан жуулчдад найдвартай, хүртээмжтэй тээврийн үйлчилгээ үзүүлэх,
- 1.2.6. Томёотой хамтран жолооч нарыг сонгон шалгаруулах,
- 1.2.7. Үйлчилгээ үзүүлэх жолооч нарыг сургах,
- 1.2.8. Өөрийн системийг жуулчдад ээлтэй буюу англи хэлээр ашиглах боломжтой, төлбөрийн олон сонголттой болгох,
- 1.2.9. Төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой бусад,

Томёогын хэрэгжүүлэх арга хэмжээ:

- 1.2.10. Төслийг хэрэгжүүлэн ажиллах жолооч нарын хэлний мэдлийг шалган, сонгон шалгаруулах,
- 1.2.11. Шаардлагатай тохиолдолд жолооч нарт гадаад хэлний болон харилцааны сургалт орох,
- 1.2.12. Төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой бусад,

Хоёр. Талуудын хамтын ажиллагааны зарчим

- 2.1. Талууд нь энэхүү Санамж бичгийн 1.1 дэх хэсэгт заасан зорилгын хэрэгжилтийн талаарх аливаа мэдээ, мэдээлэл, бичиг баримтыг харилцан тодорхой цаг хугацааны давтамжтайгаар солилцож, нээлттэй хамтран ажиллана.

- 2.2. Талууд энэхүү Санамж бичгээр тодорхойлсон зорилтуудыг хэрэгжүүлэхдээ Монгол улсын болон олон улсын хууль тогтоомжийг удирдлага болгоно.
- 2.3. Талууд энэхүү Санамж бичгээр тодорхойлсон Хамтын ажиллагааг хэрэгжүүлэх нэгдмэл нэг сонирхолтой байгаагаа илэрхийлж, үзэл баримтлал, стратеги зорилтыг нарийвчлан тогтоосны үндсэн дээр холбогдох хууль тогтоомжийн дагуу “Хамтын ажиллагааны гэрээ” байгуулна.

Гурав. Бусад

- 3.1. Энэхүү Санамж бичигт Талууд харилцан тохиролцсоноор нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд нэмэлт, өөрчлөлтийг бичгээр үйлдэнэ.
- 3.2. Санамж бичиг нь гэрээний нэгэн адил эрх зүйн үр дагавар үүсгэхгүй, заавал биелэгдэх шинжгүй бөгөөд Талуудын харилцан итгэлцэл дээр тулгуурлан хэрэгжинэ.
- 3.3. Санамж бичигтэй холбоотой үл ойлголцол, маргааныг Талууд эвийн журмаар шийдвэрлэнэ.
- 3.4. Энэхүү санамж бичгийг 1 жилийн хугацаатайгаар байгуулав.
- 3.5. Санамж бичгийг нийт 3 хувь үйлдэж, талууд тус бүр нэг хувийг хадгална.

Холбоог төлөөлж:

“Аялал жуулчлалын
мэргэжлийн холбоо” НЭЗХЭ
Дэд ерөнхийлөгч



О.Мөнхнасан

Талуудыг төлөөлж: Юбикабыг төлөөлж:

“Юбикаб” ХХК-ийн
Гүйцэтгэх захирал



О.Золбаяр

Томёог төлөөлж:

“Томё Эдтек” ХХК-ийн
Гүйцэтгэх захирал



Б.Батзул

ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ САНАМЖ БИЧИГ

2024 оны ...~~8~~ сарын ...~~11~~-ний өдөр

№.....

Монгол Улс, Улаанбаатар хот

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Нэг талаас “Монголын уул уурхайн үндэсний ассоциаци” (цаашид “МУУҮА”) гэх, нөгөө талаас “Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо” (цаашид “холбоо”, хамтад нь “Талууд” гэх) нар дор дурдсан асуудлаар харилцан тохиролцож энэхүү санамж бичгийг 2024 оны ... сарын ...-ний өдөр байгуулав.

ХОЁР. ЗОРИЛГО

- 2.1. Энэхүү санамж бичгийн зорилго нь талуудын хамтран ажиллах зарчим, чиглэлийг тодорхойлж, санамж бичигт тусгасан асуудлаар үндэсний болон олон улсын эрх зүйн жишигт нийцүүлэн үр дүнтэй, хамтран ажиллахад оршино.
- 2.2. Санамж бичигт дурдсан ажлыг хэрэгжүүлэхдээ талууд өөрсдийн дотоод нөөц, бололцоог бүрэн дайчилж ажиллана.
- 2.3. Талууд харилцан бие биеийнхээ эрх, хууль ёсны ашиг сонирхол, үнэт зүйл, нэр хүндийг эрхэмлэн хүндэтгэнэ.
- 2.4. Талууд хамтран ажиллахдаа аливаа явцуу ашиг сонирхлоос ангид байж, хууль дээдлэх, мэдлэгт суурилах, бодитой хандах зарчмыг баримтална.

ГУРАВ. ХАМТРАН АЖИЛЛАХ АЖЛЫН ЧИГЛЭЛ

- 3.1. Энэхүү санамж бичгийн хүрээнд талууд дараах чиглэлээр хамтран ажиллана. Үүнд:
 - 3.1.1. Холбоо нь Уул уурхайн 7 хоног чуулган болон MinePro экспод хүрэлцэн ирсэн гадаадын зочид төлөөлөгч нарт зориулсан олон улсын стандартад нийцсэн аялал, амралтын бүтээгдэхүүн үйлчилгээг санал болгох, холбогдох аяллыг зохион байгуулах;
 - 3.1.2. Холбоо нь арга хэмжээг Чингэс хаан шинэ нисэх онгоцны буудал дээр дэлгэцээр сурталчлах бөгөөд тус видео контентод Холбооны лого зайлшгүй орох шаардлагатай байдаг тул тус нисэх буудлаар явуулах контентэд холбооны логог оруулах эрхийг нээлттэй байлгах;
 - 3.1.3. Холбоо нь Уул уурхайн 7 хоног чуулган болон MinePro экспог өөрсдийн салбар зах зээлийн холбоодоор дамжуулан олон улсад сурталчлах;
 - 3.1.4. Холбоо нь хамтын ажиллагаатай Олон Улсын Аялал Жуулчлалын Холбоод болон ОУ-ын байгууллагуудад арга хэмжээний талаарх мэдээлэл хүргэх.
 - 3.1.5. Холбоо нь өөрсдийн цахим хуудсаар болон гишүүн байгууллагуудаар дамжуулан арга хэмжээний талаарх мэдээлэл түгээх
 - 3.1.6. МУУҮА нь арга хэмжээний хүрээнд Холбооны үйл ажиллагааг дэмжин ажиллах
 - 3.1.7. Талууд нь өөрсдийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг харилцан солилцох замаар нөгөө талынхаа үйл ажиллагаанд тус дэм болох;
 - 3.1.8. Салбар дундын төсөл, хөтөлбөрт талууд бие биеэ дэмжин оролцож, хамтран ажиллах.

ДӨРӨВ. АЖЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХЯНАЛТ

- 4.1. Талууд хамтран ажиллахдаа нөгөө талынхаа эрх, хууль ёсны ашиг сонирхлыг харилцан хүндэтгэж, хамтын ажиллагааны үр дүнд сэтгэл хангалуун байхад хүчин чармайлт гаргаж ажиллана.
- 4.2. Энэхүү санамж бичгийн хүрээнд хийгдэх ажил тус бүрийн санхүүжилтийг талууд харилцан тохиролцон шийдвэрлэнэ.
- 4.3. Энэхүү санамж бичгийн хэрэгжилт, үйл ажиллагаанд талууд хамтран хяналт тавьж ажиллана.
- 4.4. Энэхүү санамж бичгийн хүрээнд хийж гүйцэтгэсэн хамтын ажиллагаатай холбоотой ажлын талаарх тайланг талууд харилцан бие биедээ тайлагнана.
- 4.5. Талууд энэхүү санамж бичгийн хүрээнд хамтран ажиллах явцдаа олж мэдсэн буюу олж авсан нөгөө талынхаа үйл ажиллагаатай холбоотой аливаа мэдээ, мэдээлэл /үүнд:

- талуудын нууцад хамаарагдах аман болон бичгэн хэлбэрийн баримт, цахим, файл хэлбэртэй бүхий л баримт сэлт, мэдээлэл орно./-ийн нууцыг чандлан хадгалж ажиллана.
- 4.6. Хамтын үйл ажиллагааны явцад үүссэн буруутай үйл ажиллагаанаас аль нэг тал нь нөгөө талдаа буюу бусдад хохирол учруулсан тохиолдолд тусгайлсан гэрээнд заасан нөхцөлийн дагуу, хэрэв тийм гэрээ байхгүй тохиолдолд Монгол Улсын хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэнэ.

ТАВ. САНАМЖ БИЧИГ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ

- 5.1. Энэхүү санамж бичигт заасан үйл ажиллагааг сайн дурын үндсэн дээр хэрэгжүүлэх ба энэ нь талуудын хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэх бүрэн эрхийг хязгаарлах үндэслэл болохгүй.
- 5.2. Энэхүү санамж бичигт талуудын эрх бүхий этгээдүүд гарын үсэг зурж баталгаажуулсанаар 2 жилийн хугацаанд хүчин төгөлдөр болно.
- 5.3. Шаардлагатай гэж үзвэл талууд харилцан тохиролцож энэхүү санамж бичигт нэмэлт, өөрчлөлтийг бичгээр оруулж болох ба тэрхүү нэмэлт, өөрчлөлтөд талуудын эрх бүхий этгээдүүд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.
- 5.4. Энэхүү санамж бичгийг монгол хэлээр 2 /хоёр/ эх хувь үйлдэх ба талуудад хадгалагдсан хувь тус бүр хууль зүйн адил хүчинтэй байна.

САНАМЖ БИЧИГ БАЙГУУЛСАН:

МОНГОЛЫН УУЛ УУРХАЙН ҮНДЭСНИЙ
АССОЦИАЦИ:

Гүйцэтгэх захирал хатагтай
Г.ЭРДЭНЭТУЯА



(гарын үсэг, тамга)

2024 оны 2 сарын 15-ний өдөр

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН МЭРГЭЖЛИЙН
ХОЛБОО:

Гүйцэтгэх захирал
М.НАРАНГЭРЭЛ



(гарын үсэг, тамга)

2024 оны 2 сарын 14-ний өдөр

ХАРИЛЦАН ОЙЛГОЛЦЛЫН САНАМЖ БИЧИГ

2024 оны 08 дугаар сарын 15 ны өдөр

№ 08/15

Улаанбаатар хот

Энэхүү Харилцан ойлголцлын санамж бичгийг

Нэг талаас Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жуулчны гудамж, Арт хаус центр 5-р давхар хаягт байрших Улсын бүртгэлийн 9011739077, регистрийн 6303277 дугаартай "Хайпэй" ХХК, түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал Э.Сайханжаргал,

Нөгөө талаас Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Очир төв, 5 давхар, 503 тоот хаягт байрлах "Аялал Жуулчлалын Мэргэжлийн Холбоо /НЭЗХЭ/ Хятад зах зээлийн салбар холбоо" (цаашид "ХЗЗСХ" гэх)-ийг төлөөлж Тэргүүн Г.Отгонбаатар, (цаашид хамтад нь "Талууд" гэх) нар дараах нөхцөлүүдийг харилцан тохиролцож байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү Харилцан ойлголцлын санамж бичгийн зорилго нь Хайпэй ХХК болон ХЗЗСХ нь стратегийн түнш байгууллагаар хамтран ажиллах, түүнтэй холбоотой харилцан ашигтай бие биенээ дэмжсэн үйл ажиллагааг хамтран хэрэгжүүлэх нөхцөлийг тодорхой болгох, бэлтгэл ажлыг хангах, хамтран ажиллах үндсэн гэрээг байгуулах хүртэл үүсэх харилцааг зохицуулахад оршино.

ХОЁР. ХАРИЛЦАН ОЙЛГОЛЦСОН ЗҮЙЛҮҮД

- 2.1. Хайпэй ХХК нь ХЗЗСХ -ны стратегийн түнш байгууллагаар сонгогдон ажиллана.
- 2.2. Талууд БНХАУ-аас Монгол улсад ирж буй жуулчдад (Inbound) зориулан үйл ажиллагаа явуулж буй ХЗЗСХ -ны гишүүн байгууллагуудтай дараах байдлаар хамтарч ажиллана. Үүнд:
 - 2.2.1. Хайпэй ХХК нь ХЗЗСХ -ны гишүүн байгууллагуудад WeChat Pay төлбөр тооцооны шийдлийг хөнгөлттэй үнээр санал болгон ажиллана.
 - 2.2.2. ХЗЗСХ нь өөрсдийн гишүүн байгууллагуудад Хайпэй ХХК-ны санал болгож буй WeChat Pay төлбөр тооцооны шийдлийг нэвтрүүлэх тал дээр дэмжлэг үзүүлэн ажиллана.
 - 2.2.3. Хайпэй ХХК нь ХЗЗСХ -ны гишүүн байгууллагуудад БНХАУ-аас ирэх жуулчдад үйлчилгээ үзүүлэх, тэдгээрээс төлбөр тооцоо хүлээн авахтай холбоотой сургалт, сурталчилгааны ажлуудыг ХЗЗСХ -той хамтран зохион байгуулна.
 - 2.2.4. ХЗЗСХ -ноос зохион байгуулж буй хурал, зөвлөгөөн, сургалт, семинар болон бусад арга хэмжээнүүдэд Хайпэй ХХК нь дэмжигч байгууллагаар хамтран ажиллана.

САНАМЖ БИЧИГ БАЙГУУЛСАН:

"Хай пэймент солюшнс" ХХК-г төлөөлж
Гүйцэтгэх захирал:



Э.САЙХАНЖАРГАЛ

"Аялал Жуулчлалын Мэргэжлийн Холбоо
/НЭЗХЭ/ Хятад зах зээлийн салбар
Холбоо"-г төлөөлж Тэргүүн:



ХАМТРАН АЖИЛЛАХ САНАМЖ БИЧИГ

2024 оны 08 дугаар
сарын 26-ны өдөр

Дугаар 005/05

Улаанбаатар
хот

Энэ санамж бичгийг нэг талаас Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, “Очир” центрт байрлах, 8398801 регистрийн дугаартай “Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо” НЭЗХЭ, түүнийг төлөөлж Тэргүүн Дэд Ерөнхийлөгч Т. Баттулга, нөгөө талаас Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Нарны зам-62, Юнион бюлдинг, 15 давхар, В-1505, В1506 тоот хаягт байрлах 1009834 регистрийн дугаартай “Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо” ТББ, түүнийг төлөөлж Дэд Ерөнхийлөгч, Гүйцэтгэх захирал Ч.Нанжидсамбуу нар /цаашид хамтад нь “талууд” гэж/ дараах нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав.

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Энэхүү санамж бичгийн хүрээнд талууд хөдөлмөрийн зах зээл дээр аялал жуулчлалын салбарын хүний нөөцийн үнэлэмжийг дээшлүүлэхтэй холбоотой үүсэх харилцааг зохицуулна.

- 1.1. Санамж бичиг бүхэлдээ талуудын дагаж мөрдөж буй хууль тогтоомж, дүрэм, журамд нийцсэн бөгөөд санамж бичиг байгуулах болсон шалтгаан нөхцөлийн талаар бүрэн ойлголцсон байна.
- 1.2. Санамж бичгийн хүрээнд Талууд аливаа үйл ажиллагаа явуулахдаа Монгол Улсын хууль, тогтоомжийн хүрээнд ажиллана.
- 1.3. Хамтын ажиллагаа нь хууль болон бусад эрх зүйн актаар хориглоогүй асуудалд ил тод, нээлттэй байх ба хамтын ажиллагааны үр дүнг нэгтгэн хэлэлцэх, нөгөө талынхаа ажил хэргийн нэр хүндийг хүндэтгэх, нууцыг хадгалах зарчмыг баримтална.
- 1.4. Санамж бичиг нь талуудын цаашдын хамтын ажиллагаанд дагаж мөрдвөл зохих баримт бичиг мөн бөгөөд талууд хоорондоо санхүү, хууль эрх зүйн ямар нэгэн үүрэг, хариуцлага хүлээхгүй болно.

ХОЁР. САНАМЖ БИЧГИЙН ХУГАЦАА

- 2.1 Энэ санамж бичиг нь талуудын эрх бүхий албан тушаалтнууд гарын үсэг зурж, тамга, тэмдэг даран баталгаажуулсан 24 оны 08 сарын 26 өдрөөс эхлэн 3 жил /гурван жил/ жилийн хугацаанд хүчинтэй байна.

ГУРАВ. ТАЛУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

Талууд хамтран ажиллах ажлын хүрээнд:

- 3.1 Мэргэжлийн үндэсний зөвлөлд гишүүнээр элсэх
- 3.2 Ажил мэргэжлийн стандарт боловсруулах
- 3.3 Салбарын тарифын хэлэлцээрийн төслийг боловсруулах
- 3.4 Хөдөлмөрийн цалин хөлсний хэмжээ, бүтцийн судалгаа хийх

ДӨРӨВ. ҮР ДҮНГ НЭГТГЭХ

- 4.1 Талууд санамж бичгийн хэрэгжих хугацаа дуусахад хамтын ажиллагааны хүрээнд гарсан үр дүнг дүгнэн, цаашдын хамтын үйл ажиллагааг төлөвлөхийг эрмэлзэнэ.
- 4.2 Санамж бичгийн хэрэгжилт, тайланг жил бүр дүгнэн хэлэлцэж, үр дүнг тооцож ажиллана.

ТАВ. БУСАД НӨХЦӨЛ

- 5.1 Санамж бичигт Талууд харилцан тохиролцож нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд нэмэлт өөрчлөлтийг бичгээр үйлдэж, талуудын эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно. Ийнхүү оруулсан нэмэлт өөрчлөлт нь энэ Санамж бичгийн салшгүй хэсэг байна.
- 5.2 Санамж бичгийг Монгол хэл дээр 2 (хоёр) хувь үйлдэж, талууд тус бүр хувийг хадгалах бөгөөд хувь тус бүр хууль зүйн хувьд адил хүчинтэй байна.

САНАМЖ БИЧИГ БАЙГУУЛСАН:


“АЖМХ” НЭЗХЭ-ИЙН
ТЭРГҮҮН ДЭД ЕРӨНХИЙЛӨГЧ

Т. БАТТУЛГА



“МОНГОЛЫН АЖИЛ ОЛГОГЧ
ЭЗДИЙН ХӨЛБӨӨ” ТББ-ЫН
ДЭД ЕРӨНХИЙЛӨГЧ, ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ

Ч. НАНЖИДСАМБУУ



ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ САНАМЖ БИЧИГ

2024 оны 09 сарын 26-ны өдөр

Улаанбаатар хот

Энэхүү санамж бичгийг,

Нэг талаас даатгагчийг төлөөлж “МИГ Даатгал” ХХК-н Байгууллагын даатгалын газрын захирал Э. Ариун-эрдэнэ,

Нөгөө талаас “Аялал жуучлалын мэргэжлийн холбоо”-ны НЭЗХЭ-ийн дэд ерөнхийлөгч О.Мөнхнасан нар харилцан тохиролцож үйлдэв.

Нэг. Санамж бичгийн гол нөхцөл

Энэхүү санамж бичгээр Талууд доорх нөхцөлийг харилцан тохирч хамтран ажиллана. Үүнд:

Даатгалын гэрээ:

- 1.1. Аялал жуучлалын тухай хуулийн 14-р зүйлийн 14.1 болон 14.2-т заасан заавал хийгдэх даатгалуудыг “Аялал жуучлалын мэргэжлийн холбоо”-ны гишүүн байгууллагуудад даатгалын үйлчилгээ, зөвөлгөө үзүүлэх; хөнгөллттэй үнээр даатгах
- 1.2. “Аялал жуучлалын мэргэжлийн холбоо”-ноос явуулж буй олон нийтэд чиглэсэн үйл ажиллагаа бүрт даатгалын үйлчилгээ үзүүлэх, тус арга хэмжээнд оролцох боломжоор хангах;
- 1.3. “Аялал жуучлалын мэргэжлийн холбоо” нь өөрийн гишүүн байгууллагуудад “Миг Даатгал” ХХК-н бүтээгдэхүүн үйлчилгээг санал болгож хамтран ажиллах нөхцөл бололцоогоор хангах;

Хоёр. Бусад

- 2.1. Энэхүү санамж бичгийг 2 хувь үйлдэх бөгөөд талууд гарын үсэг зурж баталгаажуулснаар тус бүр нэг хувь хадгалагдана. Талуудад байгаа хувь бүр адил хүчинтэйд тооцогдоно.

САНАМЖ БИЧГИЙГ БАЙГУУЛСАН:

ДААТГАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

“МИГ Даатгал” ХХК-н
Байгууллагын даатгалын
газрын захирал

Э. АРИУН-ЭРДЭНЭ

**ДААТГУУЛАГЧИЙГ
ТӨЛӨӨЛЖ:**

“Аялал жуучлалын мэргэжлийн
холбоо”-ны НЭЗХЭ-ийн Дэд
Ерөнхийлөгч

О.МӨНХНАСАН



АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
МЭРГЭЖЛИЙН ХОЛБОО
Нийтийн эрх зүйн хуулийн этгээд



“АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН МЭРГЭЖЛИЙН ХОЛБОО” НИЙТИЙН ЭРХ ЗҮЙН ХУУЛИЙН
ЭТГЭЭД БОЛОН “НЬЮ УЛААНБААТАР ИНТЕРНЭЙШНЛ ЭЙРПОРТ” ХХК
ХООРОНД ХАМТРАН АЖИЛЛАХ САНАМЖ БИЧИГ

Memorandum of Understanding Between the "Mongolian Tourism Organization," a
Legal Entity under Public Law, and "New Ulaanbaatar International Airport" LLC

2024 оны... сарын-ны өдөр
Date:/..../2024

№ 382/24


Улаанбаатар хот
Ulaanbaatar city

Энэхүү Санамж бичгийг Монгол Улсын агаарын хилээр нэвтрэх жуулчдын тоо, агаарын тээврийн эрэлт, нийлүүлэлтийг тэнцвэржүүлэх, олон улсад Монгол Улсыг сурталчлах хамтын ажиллагааг дэмжих зорилгоор нэг талаас СБД, 1-р хороо, Олимп гудамж, Очир центр, 5 давхар 503 тоот хаягт байрлах, 8398801 регистрийн дугаартай “Монголын Аялал Жуулчлалын Холбоо” НЭЗХЭ-ийг төлөөлж ерөнхийлөгч Ц.Баатарсайхан болон нөгөө талаас 41090 Төв аймаг, Сэргэлэн сум, Эрдэнэ-Уул 4-р баг, Тахилт толгой хаягт байрлах, 3874095 регистрийн дугаартай “Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт” ХХК-ийг төлөөлж Гүйцэтгэх захирал Китанака Тэкэфуми нар хоёр (2) жилийн хугацаатайгаар байгуулж байна.

This Memorandum of Understanding is entered into for a period of two (2) years for the purpose of balancing the number of tourists entering Mongolia through its air border, matching the demand and supply in air transportation, and promoting Mongolia internationally. It is made between the following parties:

On the one side, the Mongolian Tourism Organization, a Legal Entity under Public Law, located at Room 503, 5th floor, Ochir Center, Olympic Street, Sukhbaatar District, 1st Khoroo, with registration number 8398801, represented by President Baatarsaikhan.Ts, and

On the other side, New Ulaanbaatar International Airport LLC, located at Takhilt Tolgoi, Erdene-Uul, 4th Bag, Sergelen Soum, Tuv Province, with registration number 3874095, represented by CEO Kitanaka Takefumi.



Энэхүү Санамж бичгийг Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр сайн дураар, хууль журмыг хүндэтгэн, харилцан эрх ашгийг хамгаалан, хамтын ажиллагааны зарчимд тулгуурлан харилцан ойлголцож, байгуулсан болно.

This Memorandum of Understanding is entered into voluntarily by the Parties, based on mutual agreement, with respect for laws and regulations, and in consideration of mutual interests, founded on the principles of cooperation and mutual understanding.

Энэхүү санамж бичгийн хүрээнд хэрэгжүүлэх хамтын ажиллагааны зорилго нь, агаарын хилээр нэвтрэх жуулчдын тоог нэмэгдүүлэх, нисэх буудлаар үйлчлүүлж байгаа жуулчдын сэтгэл ханамжийг дээшлүүлэх, Монгол Улсыг олон улсад сурталчлах, зорилтот зах зээлийн орнуудаас шинэ чиглэл нээх, агаарын тээврийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтийг тэнцвэржүүлж зорчигч жуулчны урсгалыг тогтмол нэмэгдүүлэх чиглэлээр агаарын тээвэрлэгч болон аялал жуулчлалын байгууллагуудын хооронд хамтын ажиллагааг дэмжихэд оршино.

The purpose of the cooperation under this Memorandum of Understanding is to increase the number of tourists entering through Mongolia's air border, enhance the satisfaction of tourists using the airport, promote Mongolia internationally, establish new routes from target market countries, balance the supply and demand in the air transportation market, and steadily increase the flow of passenger tourists by fostering cooperation between air carriers and tourism organizations.

Дараах хамтын ажиллагаа, арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахаар тохиролцов. Үүнд:

Agreed to implement the following collaboration and actions:

Салбар хоорондын харилцан ашигтай хамтын ажиллагааг дэмжих;

To promote mutually beneficial cooperation between sectors;

Агаарын хилээр нэвтрэх жуулчдын тоог нэмэгдүүлэх, шинэ чиглэлийг хөгжүүлэх зорилгын хүрээнд хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, хамтран ажиллах;

To implement joint projects and programs and to collaborate in order to increase the number of tourists entering through the air border and to develop new routes.

Судалгаа, статистик, мэдээллүүдийг харилцан солилцож зорилтот зах зээл орнуудаа хамтран тодорхойлж, түүнд чиглэсэн сурталчилгаа, арга хэмжээг уялдаа холбоотойгоор зохион байгуулах; (Агаарын тээвэрлэгчдийн бизнесийн нууцад хамаарах мэдээллийг олон нийтэд түгээх, бусад зах зээл эзэмшигчдэд өгөхгүй байх)

To share research, statistics, and information with each other, jointly identify target market countries, and coordinate advertising and events aimed at these markets; (To refrain from disclosing information related to the business secrets of air carriers to the public or to other market competitors).

Аялал жуулчлалын компаниуд болон агаарын тээвэрлэгчдийг холбосон уулзалт хурал зохион байгуулах, мэдээллээр хангах;

To organize meetings and conferences connecting tourism companies and air carriers, and to provide them with information.

АЖМХ нь гадаадын аялал жуулчлалын компаниудын төлөөллийг Монголд урьж Монгол Улсыг таниулах арга хэмжээг зохион байгуулах ба НУБИЭ ХХК нь шаардлагатай тохиолдолд (шинэ агаарын тээврийн компанийн мэдээлэл болон шинэ чиглэлийн мэдээллээр хангах гэх мэт) дэмжлэг үзүүлнэ;

The Mongolian Tourism Association will organize events to promote Mongolia by inviting representatives of foreign tourism companies to the country, and, as needed, New Ulaanbaatar International Airport LLC will provide support (such as supplying information on new airlines and new routes).

Олон улсын арга хэмжээ, уулзалт, үзэсгэлэнд шаардлагатай тохиолдолд хамтран оролцох, үйл ажиллагааг хамтран зохион байгуулах;

To jointly participate in international events, meetings, and exhibitions as necessary, and to collaboratively organize activities.

Хамтын ажиллагааны зорилтуудын хүрээнд өөрсдийн гишүүдэд мэдээлэл хүргэх;

To provide information to their respective members within the framework of the cooperation objectives.

АЖМХ нь НУБИЭ ХХК-д бусад улс орны аялал жуулчлалын байгууллагаас албан ёсны мэдээ мэдээлэл, статистик судалгаа авахад туслалцаа үзүүлэх;

Mongolian Tourism Organization will assist New Ulaanbaatar International Airport LLC in obtaining official information and statistical research from tourism organizations in other countries.

Нисэх буудалд жуулчдад зориулсан идэвхжүүлэлтийн арга хэмжээ болон судалгааны ажил зохион байгуулахад боломжит зай талбайгаар хангах, зохион байгуулалтад дэмжлэг үзүүлэх;

To provide available space and support in organizing promotional activities and research work for tourists at the airport.

МУ-ын Засгийн газар, төрийн байгууллагад хамтын санал, дуу хоолойг хүргэх;

To convey joint proposals and voices to the Government of Mongolia and state organizations.

Хууль тогтоомжийн өөрчлөлт, шинэчлэлтэй холбоотой мэдээллийг солилцох.

To exchange of information related to legislative changes and reforms.

Талууд энэхүү Санамж бичигт тусгайлан дурдсан зорилго, хүлээгдэхээр заасан үр дүнгээс бусад аливаа үүрэг хүлээгээгүй, амлалт өгөөгүй болно.

The parties have not made any obligations or promises other than the purposes and expected results specified in this Memorandum.

Энэхүү Санамж бичгийн Англи, монгол хэл дээрх утга агуулга зөрүүтэй байх тохиолдолд англи хэл дээрх утга агуулгын дагуу зохицуулна.

In case there is a discrepancy between the meaning of this Memorandum in English and Mongolian, the Memorandum in English shall prevail.



Энэхүү санамж бичгийг 2 хувь үйлдэж, 2024 оны-р сарын ...-ны өдөр Улаанбаатар хотод гарын үсэг зурав.

This memorandum of understanding was signed in two originals on....., 2024, in Ulaanbaatar.

**САНАМЖ БИЧИГ БАЙГУУЛСАН:
MEMORANDUM OF UNDERSTANDING SIGNED BY:**

“НЬЮ УЛААНБААТАР ИНТЕРНЭЙШНЛ”

ХХК-ийг төлөөлж

On behalf of “NEW ULAANBAATAR
INTERNATIONAL AIRPORT” LLC

.....
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ:
КИТАНАКА ТАКЭФУМИ
CEO
ТАКЭФУМИ КИТАНАКА



**“АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
МЭРГЭЖЛИЙН ХОЛБОО” НЭЗХЭ-ийг**

төлөөлж

On behalf of “MONGOLIAN TOURISM
ORGANIZATION”

.....
ЕРӨНХИЙЛӨГЧ:
Ц.БААТАРСАЙХАН
PRESIDENT
BAATARSAIKHAN.TS



MEMORANDUM OF UNDERSTANDING

BETWEEN THE MONGOLIAN TOURISM ORGANIZATION AND THE

TOURISM INDUSTRY DATA ANALYTICS LAB OF SEJONG UNIVERSITY

I. Introduction

The two institutions herewith enter into a Memorandum of Understanding to enhance the relationship between them and to possibly develop new collaborative undertakings in the years to come. This agreement is intended to help facilitate a meaningful and mutually beneficial relationship between the two institutions.

II. Purposes

Both the Mongolian Tourism Organization (hereafter MTO) and Tourism Industry Data Analytics Lab of Sejong University (hereafter TIDAL) wish to pursue a collaborative relationship to the greatest extent possible regarding **professional development of the talents for the Mongolian tourism industry.**

III. Specific Activities

The two institutions may develop specific activities to implement the mutual understanding set forth in this memorandum. These shall in every case be subject to mutual consent and the availability of adequate resources, and shall be set forth in supplementary sub-agreements or protocols.

IV. Communication between the Institutions


Both institutions shall communicate with each other on a need basis, for MTO through Nina Sayzana, officer of MTO, and for TIDAL through Zhala Huseynova, research staff of TIDAL.

V. Duration of the Agreement

The agreement shall take effect upon approval by both parties and shall remain in effect for an initial period of five years. Thereafter it shall be automatically renewed from year to year; however, after the initial period either party may terminate the agreement at the end of a given year by providing a six-month notice in writing of such intent. Termination of the agreement will not affect members of either institution already participating in a joint program/project so that they may complete the agreed-upon duration of their participation.

MONGOLIA TOURISM ORGANIZATION (MTO)

TOURISM INDUSTRY DATA ANALYTICS LAB



Mrs. Narangerel Manaljav
CEO
Date: 11 Dec 2024.



Dr. Seul Ki Lee
Director
Date: 11 Dec. 2024